







ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО - 2018



<http://www.ubstat.mn>



ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Монгол Улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1116 тоот захирамж, Дүүргийн Засаг Даргын А/384 тоот захирамжаар Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан тооллого явуулах удирдамж, зааврын дагуу 2018 оны мал, тэжээвэр амьтдын тооллогыг 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж явууллаа.

Энэхүү танилцуулгад орж байгаа статистикийн үзүүлэлтүүдийг дүүргийн мал, тэжээвэр амьтдын 2018 оны тооллогын мэдээллийг боловсруулж, Үндэсний Статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн, олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу тооцож, үр дүнг гаргалаа.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөнүржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эхүүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй гэрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод,

6 хонь = 1 бод, 8 ямаа = 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ = 5 хонь, 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь

1 хонь = 1 хонь, 1 ямаа = 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүрдээр сүүлийн 2 насны эх малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана. Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоо гэх нийт малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоогоны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Бүүр - 20-25 Азарга - 12-15 Бүх - 35-45 Хуц, ухна - 25-30

Малын зүй бус хорогдол: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага:

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

2. Хүнсний хэрэглээний малын тоо= Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоодод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн – Худалдаж авсан, шилжижирсэн).

Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн

Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно. Идээгүй тохиолдолд тэнцэж байх учиртай.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг. Үүний тулд дараахь итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.


Хадлан өвс	0.45
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Гартэжээл, хужир шүү	1.0
Төмс ногооны хаягдал	0.22
Үр тарианы хаягдал	0.9
Лай	0.4
Сүрэл	0.25

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Малын тоо, бүтэц: Хан-Уул дүүрэгт 2018 оны мал тооллогоор нийт 33208 толгой мал тоологдсон нь 2017 оноос 5277 (13.7%) толгой малаар буурсан байна. Нийслэлийн хэмжээнд 2018 онд 411781 толгой мал тоологдсон бөгөөд дүүргийн мал 8.1 хувийг эзэлж, өмнөх оноос 1.2 пунктээр буурсан байна.

Зураг 1. Дүүргийн нийт малын тоо, оноор



Малын таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 2 толгойгоор (3.0 дахин) өсч, адуу 502 толгойгоор (8.0%), үхэр 1385 толгойгоор (11.0%), хонь 1318 толгойгоор, (13.3%) толгойгоор, ямаа 2074 толгойгоор (21.3%) тус тус буурчээ.

Иргэдийн хувийн мал 32980 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 220 болж 2017 оноос иргэдийн мал 4860 (12.8%) толгойгоор буурч, аж ахуйн нэгж, байгууллагын мал 425 (65.9%) толгойгоор буурчээ.

Хүснэгт 1. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018	Өсөлт, бууралт	
						Тоо	Хувь
Малын тоо, бүгд	42686	37520	38860	38485	33208	-5277	-13.7
Тэмээ	15	1	7	1	3	2	2.0*
Адуу	5895	5918	7451	6247	5745	-502	-8.0
Үхэр	11110	12043	12274	12616	11231	-1385	-11.0
Хонь	14332	9944	9958	9894	8576	-1318	-13.3
Ямаа	11334	9614	9170	9727	7653	-2074	-21.3
Хонин толгойд шилжүүлснээр**	132533	132286	144047	138078	123080	-14998	-10.9

* дахин

** Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ= 5 хонь, 1 адуу= 7 хонь, 1 үхэр=6 хонь, 1 хонь= 1 хонь, 1 ямаа=0.9 хонь

2018 онд дүүргийн 12-р хорооны мал 14.7 хувиар, 13-р хорооных 11,4 хувиар, 14-р хорооных 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Малын тоо, хороогоор

Хороо	2017	2018	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт %
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
4-р хороо	136	-	-	-	-	-	-	-
5-р хороо	152	-	-	-	-	-	-	-
6-р хороо	161	-	-	-	-	-	-	-
7-р хороо	-	-	-	-	-	-	-	-
8-р хороо	445	-	-	-	-	-	-	-
9-р хороо	1026	-	-	-	-	-	-	-
10-р хороо	435	-	-	-	-	-	-	-
11-р хороо	46	-	-	-	-	-	-	-
12-р хороо	5939	5065	-	843	2376	576	1270	-14.7
13-р хороо	13555	12013	-	1460	4754	2910	2889	-11.4
14-р хороо	16577	16130	3	3442	4101	5090	3494	-2.7
16-р хороо	13	-	-	-	-	-	-	-
Дүн	38485	33208	3	5745	11231	8576	7653	-13.7

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 16130 толгой малаар 14-р хороо тэргүүлж, өмнөх оноос 477 толгой малаар буурсан байна. Хамгийн цөөн малтай нь 12-р хороо 5065 толгой малтай байна. 2018 онд нийт мал сүргийн 48.8 хувийг бог мал, 51.2 хувийг бод мал эзэлж байна. Нийт малын сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр нь дараахь хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3. Нийт малд эзлэх хувийн жин, малын төрлөөр

	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийт мал	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.1	0.2	0.0	0.0	0.02	0.0	0.01
Адуу	11.4	11.3	13.8	15.8	19.2	16.2	17.3
Үхэр	26.6	27.5	26.0	32.1	31.58	32.8	33.82
Хонь	28.7	27.6	33.6	26.5	25.6	25.7	25.83
Ямаа	33.2	33.4	26.6	25.6	23.6	25.3	23.05

Нийт мал сүргийн 0.01 хувийг тэмээ, 33.82 хувийг үхэр, 17.3 хувийг адуу, 25.85 хувийг хонь, 23.05 хувийг ямаа эзэлж байна. Малын нийт дүнд эзлэх хувийн жинг өмнөх онуудтай харьцуулахад малын 5 төрөл дээр харьцангуй хэвийн байна. Бог малын бүтцийн хувьд нийт бог малын 52.8 хувийг хонин сүрэг, 47.2 хувийг ямаан сүрэг эзэлж байна.


Малтай өрх, малчдын тоо: Хан-Уул дүүрэгт 2018 оны мал тооллогоор нийт 33208 толгой мал тоологдсон нь 2017 оноос 5277 (13.7%) толгой малаар буурсан байна. 2018 оны мал тооллогын дүнгээр хувийн малтай 700 өрх, үүний дотор 182 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Өнгөрсөн оноос малтай өрхийн тоо 109 өрхөөр буурч, малчин өрхийн тоо 29 өрхөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Малтай өрх, малчдын насны бүлгээр

Он	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Түүний ам бүлийн тоо	Малчдын тоо	Насны бүлэг				Нийт малчдаас эмэгтэй
					15 хүртэлх насны	16-34 насны	35-59, 35-54 насны	60,55-аас дээш насны	
2007	984	293	947	644	-	223	250	171	208
2008	854	300	1098	605	-	212	235	164	192
2009	933	178	547	178	-	29	106	43	62
2010	937	176	609	319	-	58	164	97	98
2011	877	287	375	421	-	19	210	112	158
2012	840	56	201	110	-	31	63	16	50
2013	809	100	356	185	-	42	125	18	85
2014	728	104	364	209	-	59	122	28	100
2015	816	106	385	216	-	57	140	19	95
2016	836	206	704	389	-	85	252	52	164
2017	809	153	610	281	6	79	163	33	108
2018	700	182	602	288	-	75	185	28	117

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 26.1 хувь нь 16-34 насны, 64.2 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 9.7 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Нийт малчдын 117 хүн буюу 40.6 хувь нь эмэгтэй малчид байна.

Зураг 2. Малчдын тоо, насны бүлгээр



Дүүргийн малчин өрх, малчдын тоог өнгөрсөн онтой харьцуулахад малчин өрхийн тоо 29 өрхөөр (15.9%), малчдын тоо 7 хүнээр (2.4%) өссөн байна.

Малчин өрхийн 67.6 хувь нь цахилгаан эх үүсвэртэй, 59.3 хувь нь телевизортой өрх эзэлж байна.

“Амины мал”-ын тоо: Иргэдийн хувийн өмчийн малын тоо 2018 онд 32988 толгой болж, нийт малын 99.3 хувийг эзэлж байна. Тоологдсон адууны 17.3 хувь, үхрийн 33.5 хувь, хонины 25.9 хувь, ямааны 23.2 хувийг хувийн өрхийн мал эзэлж байна.

Хүснэгт 5. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлтээр, 2018 он

Малын бүлэглэлт	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Амины малын тоо	Үүнээс: малын төрлөөр				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
10 хүртэл	267	852	1527	-	168	1333	-	26
11-30	201	653	3734	-	933	2749	19	33
31-50	87	280	3362	-	1073	1951	127	211
51-100	80	286	5607	2	1313	3076	533	683
101-200	34	112	4738	-	1220	842	1180	1496
201-500	20	74	5902	-	363	629	2428	2482
501-999	9	34	5369	-	440	287	2742	1900
1000-1499	1	4	1088	-	20	60	606	402
1500-2000	1	3	1661	-	193	127	921	420
Дүн	700	2298	32988	2	5723	11054	8556	7653

* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ= 5 хонь, 1 адуу= 7 хонь, 1 үхэр=6 хонь, 1 хонь= 1 хонь, 1 ямаа=0.9 хонь

Дүүргийн малтай нэг өрхөд 47.1 толгой мал, хонин толгойд шилжүүлсэнээр* 174 толгой мал ногдож байна. Малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 14.4 толгой мал, хонин толгойд шилжүүлсэнээр 53 бог мал ногдож байна.

Мал төллөлт, төл бойжилт: 2018 онд 11695 хээлтэгч мал төллөж, 11732 төл гарсны 11044 төл (94.1%) нь бойжиж байна. Бойжуулсан төлийн тоо 2018 онд 11044 болж, өмнөх оноос 3136 толгойгоор (22.1%) буурчээ.

Зураг 3. Бойжуулсан төл, оноор



Бойжуулсан нийт төлийн 8.4 хувийг унага, 36.7 хувийг тугал, 30.1 хувийг хурга, 24.7 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 6. Төл бойжилт, мал тооллогын дүнгээр

Үзүүлэлт	2017	2018	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	14922	11732	-	998	4195	3499	3040
Бойжуулсан төл	14180	11044	-	931	4055	3327	2731
Хорогдсон төл	742	688	-	67	140	172	309
Бойжилтын хувь	95.0	94.1	-	93.3	96.7	95.1	89.8

2018 оны мал тооллогын дүнгээс харахад нийт 11732 гарсан төлийн 688 (5.9%) толгой нь хорогдож, төл бойжилт 94.1 хувьтай байна. Хорогдсон төл малын тоо 2017 оноос 54 толгойгоор буурчээ. Нийт хорогдсон малын 9.7 хувийг унага, 20.3 хувийг тугал, 25.0 хувийг хурга, 44.9 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 7. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Худалдсан	Шилжүүлсэн
Ботго	-	-	-	-	-	-	-	-
Унага	998	998	67	931	19	26	27	237
Тугал	4195	4195	140	4055	65	137	641	588
Хурга	3494	3499	172	3327	15	40	170	826
Ишиг	3008	3040	309	2731	16	41	381	661
Бүгд	11695	11732	688	11044	115	244	1219	2312

2018 онд нийт 11044 төл бойжуулсанаас 115 төл нь бусдаас худалдан авсан, 244 төл нь шилжиж ирсэн байна. Мөн 1219 төлийг бусдад худалдаж, 2312 төл шилжүүлсэн байна. 2018 онд худалдсан төлийг төрлөөр нь авч үзвэл: унага 27 толгой, тугал 641 толгой, хурга 170 толгой, ишиг 381 толгой төл худалджээ.

Бэлэн тоологдсон төл: 2018 оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 7872 толгой болж өнгөрсөн оныхоос 3596 толгой (31.3%) төлөөр буурсан байна.

Хүснэгт 8. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

Төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Өсөлт, бууралт	
								хувь	тоо
Ботго	5	-	1	-	-	-	-	-	-
Унага	871	941	1026	1055	1069	1010	712	-29.5	-298
Тугал	2914	3054	3694	3981	3433	4116	3028	-26.4	-1088
Хурга	3568	3743	4415	3288	3223	3369	2386	-29.2	-983
Ишиг	3073	3425	3350	2952	2424	2973	1746	-41.3	-1227
Бүгд	10431	11163	12486	11276	10149	11468	7872	-31.4	-3596

Том малын зүй бус хорогдол: Оны эхний малын 4.6 хувьтай тэнцэх 1775 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 65.9 хувиар өсчээ. Хорогдсон нийт малын 16.2 хувийг адуу, 24.3 хувийг үхэр, 26.9 хувийг хонь, 32.6 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 189 толгой (10.6%) мал өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 9. Том малын зүй бус хорогдол

Үзүүлэлт	2017	2018	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	1070	1775	-	287	432	477	579
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	254	189	-	15	30	42	102
Хорогдсон хээлтэгч	232	471	-	69	101	140	161

Малын хэрэглээний орлого зарлага: 2018 онд оны эхний нийт малын 1809 (4.7%) толгой малыг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 23.9 хувийг хонь, 23.2 хувийг ямаа, үлдсэн 52.9 хувийг бод мал эзэлж байна.

Хүснэгт 10. Малын хэрэглээний орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Орлого			Хасагдсан				
	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Шилжүүлсэн	Алдсан, Хулгайлагдсан олдохгүй	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Тэмээ	2	1	-	1	-	-	-	-
Адуу	148	1886	712	2314	151	389	107	287
Үхэр	290	1735	3028	2820	37	2299	850	432
Хонь	97	2184	2386	2689	4	2382	433	477
Ямаа	158	1534	1746	2412	12	2090	419	579
Дүн	695	7340	7872	10236	204	7160	1809	1775

Дээрх хүснэгтээс харахад энэ жилийн малын орлого талд тооллогоор худалдаж авсан 695 толгой, бэлэн тоологдсон төл 7872 толгой, шилжиж ирсэн 7340 толгой мал байна. Харин шилжүүлсэн 10236 толгой мал, зүй бусаар 1775 толгой мал хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн 1809 толгой мал, 7160 толгой малыг зах зээлд борлуулж зарлага талын үзүүлэлтийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11. Малын тооны өөрчлөлтөд нөлөөлсөн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
						тоо	хувь
Бэлэн тоологдсон төл	12486	11276	10149	11468	7872	-3596	68.6
Том малын зүй бусын хорогдол	293	552	751	1070	1775	705	165.9
Хээлтэгч малын тоо	19471	16572	17812	17833	16737	-1096	93.8
Хээл хаясан хээлтэгч	367	233	762	531	1084	553	204.1
Сувайрсан хээлтэгч	2289	2155	2710	2313	4531	2218	195.9

2018 онд бэлэн тоологдсон төл 31.4 хувиар, хээлтэгч малын тоо 6.2 хувиар буурч, том малын зүй бусын хорогдол 65.9 хувиар, сувайрсан хээлтэгч 95.9 хувиар, хээл хаясан хээлтэгч 2.0 дахин өссөн байна.

Малын хээл хаялт, сувайралт: 2018 онд оны эхний хээлтэгч малын 31.5 хувьтай тэнцэх хээлтэгч мал төл өгөөгүй ба үүний 4531 эх мал сувайрсан, 531 эх мал хээл хаясан байна. Энэ нь өмнөх оноос сувайрсан мал 2218 толгойгоор, хээл хаясан мал 553 толгойгоор өссөн байна. Нийт төл өгөөгүй хээлтэгч малын 50.7 хувийг бог эзэлж байна.

Хүснэгт 12. Сувайрсан болон хээл хаясан мал, төрлөөр

Төрөл	Төл өгөөгүй хээлтэгч мал			Үүнээс:					
				Сувайрсан			Хээл хаясан		
	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
Ингэ	1	-	-	1	-	-	-	-	-
Гүү	506	510	1036	436	405	776	70	105	260
Үнээ	1235	1035	1735	1178	946	1549	57	89	186
Эм хонь	690	579	1314	436	460	1101	254	119	213
Эм ямаа	1040	720	1530	659	502	1105	381	218	425
Бүгд	3472	2844	5615	2710	2313	4531	762	531	1084

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хан-Уул дүүргийн нийт мал сүргийн 7872 (23,7%) нь төл мал, 16737 (50.4%) нь хээлтэгч мал, 537 нь хээлтүүлэгч мал байна. Малын үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад дүүргийн хувьд нэг хээлтүүлэгчид дунджаар 108.1 эм хонь, 112.2 эм ямаа ногдож, хээлтүүлгийн тохироо алдагдсан байна.

Хүснэгт 14. Хээлтүүлэгч малын тоо


Төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Өсөлт, бууралт /тоо/
Буур	1	1	-	2	-	-	-	-	-
Азарга	290	318	346	331	345	418	325	350	25
Бух	67	85	92	98	97	114	106	110	4
Хуц	92	88	86	114	71	56	56	41	-15
Ухна	49	92	90	91	77	55	48	36	-12
Бүгд	499	584	614	636	590	643	535	537	2

Хээлтэгч мал: 2018 оны мал тооллогоор 16737 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 900 толгой (5.1%) малаар буурсан байна. Хээлтэгч малын бууралтад үнээ 154 толгой, эм хонь 348 толгой, эм ямаа 590 толгойгоор тус тус буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 15. Хээлтэгч мал, төрлөөр

Төрөл	2014	2015	2016	2017	2018	Өсөлт, бууралт	
						тоо	хувь
Ингэ	8	-	4	1	1	-	100.0
Гүү	1685	1591	2207	1966	2158	192	109.8
Үнээ	5146	5585	6072	6259	6105	-154	97.5
Эм хонь	7137	4833	4957	4782	4434	-348	92.7
Эм ямаа	5495	4563	4572	4629	4039	-590	87.3
Бүгд	19471	16572	17812	17637	16737	-900	94.9

Зураг 4. Хээлтэгч малын тоо



2018 онд дүүргийн нийт малын 50.4 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Үүнд: тэмээн сүргийн 33.3 хувь, адуун сүргийн 37.6 хувь, үхэр сүргийн 54.4 хувь, хонин сүргийн 51.7 хувь, ямаан сүргийн 52.8 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Бэлтгэсэн хадлан тэжээл: Дүүргийн хэмжээнд 2018 оны мал тооллогын дүнгээр 5205.1 тонн хадлан, үүнээс өөрсдийн бэлтгэсэн нь 1132.5 тонн, гар тэжээл 1282.9 тонн, хужир шүү 102.4 тонныг тус тус бэлтгэсэн дүнтэй байна. 2017 онтой харьцуулахад хадлан 259.4 тонн (4,7%), гар тэжээл 632.4 тонн (33.0%), хужир шүү 102 тонн (49.9%) -оор тус тус буурсан байна.

Хүснэгт 18. Бэлтгэсэн хадлан тэжээл, тн

Төрөл	2016	2017	2018	Өсөлт, бууралт
Хадлан	3329.7	5464.5	5205.1	-259.4
Гар тэжээл	277.9	1915.3	1282.9	-632.4
Хужир шүү	32.3	204.4	102.4	-102.0

2018 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор 1058 малын хашаа, 234 худаг тоологдсон нь 2017 оноос малын хашаа 10.1 хувиар, худаг 15.3 хувиар өссөн байна.

Тэжээвэр амьтад: Мал, тэжээвэр амьтдын 2018 оны тооллогоор 62 өрх, 11 аж ахуйн нэгжийн 3753 гахай, туулай 34, цацагт хяруул 47, галуу 31, 391542 шувуу, үүнээс 391114 тахиа тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад шувуу болон тахианы тоо 8.5 хувиар өсч, гахайн тоо 10.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 19. Тэжээвэр амьтдын тоо

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
Гахай	6555	7901	5926	5007	4174	3753
Шувуу	240672	274887	269307	322527	360722	391542
Үүнээс: тахиа	240570	274676	268837	321340	360201	391114
Зөгийн бүл	-	-	10	11	-	-

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2018 онд 328.8 тонн гахайн мах, 115.8 тонн шувууны мах, 68.7 сая ширхэг өндөг нийт 20.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Гэрийн тэжээвэр муур, нохой: Дүүргийн 16 хороонд 2018 онд гэрийн тэжээвэр 5630 нохой, 222 муур байна. Бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохойн тоо 90 -ээр (1,6%), муурны тоо 94 -өөр (73,4%) өссөн байна.

Хүснэгт 18. Тэжээвэр нохой, муурны тоо, хороогоор

Хороо	Нохой			Муур		
	2017	2018	Өсөлт, бууралт	2017	2018	Өсөлт, бууралт
1-р хороо	22	24	109.1	6	3	50
2-р хороо	28	33	117.9	-	2	-
3-р хороо	13	55	4.2*	3	3	100.0
4-р хороо	320	257	80.3	2	54	27.0*
5-р хороо	456	420	92.1	17	7	41.2
6-р хороо	473	353	74.6	9	6	66.7
7-р хороо	351	354	100.9	7	4	57.1
8-р хороо	753	786	104.4	5	5	100
9-р хороо	752	798	106.1	-	3	-
10-р хороо	634	505	79.7	6	11	183.3
11-р хороо	72	41	56.9	3	6	2.0*
12-р хороо	121	396	3.3*	2	42	21.0*
13-р хороо	590	513	86.9	37	54	145.9
14-р хороо	527	561	106.5	22	20	90.9
15-р хороо	23	30	130.4	3	2	66.7
16-р хороо	405	504	124.4	6	0	0
Нийт	5540	5630	101.6	128	222	173.4

*дахин

Тэжээвэр нохойны тоог хороогоор авч үзвэл 1,2,3,7,8,9,12,14,15,16-р хорооны нохойны тоо 0.9%-4.2 дахин өсч, 4,5,6,10,11,13-р хорооны нохойны тоо 7.9-43.1 хувиар буурчээ. Нийт бүртгэгдсэн тэжээвэр нохойны 28.1 орчим хувь нь 8-р хороо, 9-р хороонд байна.

Тэжээвэр муурны тоо 1,2,5,6,7,9,14,15-р хороонд 9.1 - 58.8 хувиар буурч, 3,4,10,11,12,13-р хороонд 50.0 хувиас 27 дахин өсчээ. Харин 16-р хороо муургүй болж, 3, 8-р хорооны муурны тоо өнгөрсөн оны түвшинд байна.

ДУГНЭЛТ

Хан-Уул дүүрэгт 2018 оны мал тооллогоор нийт 33208 толгой мал тоологдсон нь 2017 оноос 5277 (13.7%) толгой малаар буурсан байна. Малын тоо толгойн бууралтад үхэр сүрэг 1385 (26.2%) толгой, хонин сүрэг 1318 (25.0%) толгойгоор, ямаа 2074 (39.3%) толгойгоор тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. 2018 онд бог малын бүтцэд нийт бог малын 25.8 хувийг хонин сүрэг, 23.0 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд малтай 3 хороонд 700 өрх, 7 ААНБ-ын нийт 33208 толгой мал тоологдсоныг малын төрөл тус бүрээр авч үзвэл:

- ✓ тэмээ 3
- ✓ адуу 5745
- ✓ үхэр 11231
- ✓ хонь 8576
- ✓ ямаа 7653 толгой байна.

Малын таван төрлөөр 2017 онтой харьцуулахад тэмээ 2 толгойгоор өсч, адуу 502 толгой (8.0%), хонь 1318 (13.3%) толгой, үхэр 1385 толгой (11.0%), ямаа 2074 (21.3%) толгойгоор тус тус буурчээ.

Нийт мал сүргийн 0.01 хувийг тэмээ, 17.3 хувийг адуу, 33.8 хувийг үхэр, 25.8 хувийг хонь, 23.0 хувийг ямаа эзэлж байна. Нийт малын 50.4 хувийг хээлтэгч мал, 33.3 хувийг төл мал эзэлж байна. 2018 оны мал тооллогоор нийт 11732 төл гарсны 688 (5.9%) толгой нь хорогдож, төл бойжилт 94.1 хувьтай байна.

2018 онд дүүргийн хэмжээнд 62 өрх, 11 аж ахуйн нэгж байгууллагын 3759 гахай, 391542 шувуу, үүнээс 391114 тахиа тоологджээ. 2018 оны дүүргийн нохой, муурны бүртгэлээр гэрийн тэжээвэр нохой 5630, муур 222 бүргэгдсэн байна.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Хавсралт

Хүснэгт 1. Тэмээ, толгой

Хороо	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
11	-	-	1	1	1	1	-	1	1	-
12	1	1	35	45	-	-	-	-	-	-
13	5	-	-	-	1	-	-	-	-	-
14	-	-	-	2	2	14	1	6	-	3
Дүн	6	1	36	48	4	15	1	7	1	3

Хүснэгт 2. Адуу, толгой

Хороо	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
4	56	32	40	8	8	11	14	12	2	-
5	4	3	3	1	3	1	2	5	6	-
6	5	1	-	-	-	-	-	-	4	-
7	23	27	15	26	76	27	41	162	-	-
8	6	5	-	-	2	125	115	154	109	-
9	3	3	2	6	9	28	11	4	17	-
10	68	54	67	162	137	27	23	67	29	-
11	10	42	22	2	1	3	1	6	-	-
12	178	136	169	302	264	424	430	634	434	843
13	939	643	751	1084	1412	1707	1806	1941	1884	1460
14	149	238	2481	3215	3474	3542	3475	4466	3762	3442
16	6	5	1	2	2	-	-	-	-	-
Дүн	2788	3331	3551	4808	5388	5895	5918	7451	6247	5745

Хүснэгт 3. Үхэр, толгой

Хороо	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2017	2018
4	272	234	238	168	152	139	177	155	134	-
5	126	138	129	128	144	126	155	213	146	-
6	66	70	82	76	41	68	76	55	75	-
7	70	78	27	39	16	17	25	36	-	-
8	266	156	129	104	70	183	258	358	202	-
9	193	184	115	124	100	104	162	196	250	-
10	403	332	329	364	290	211	236	253	220	-
11	58	47	21	30	31	52	58	64	45	-
12	1367	1392	1672	1553	1776	2182	2626	2686	2571	2376
13	2945	2948	3232	3122	3594	4170	4588	4321	4820	4754
14	1884	2170	2643	3076	3320	3821	3633	3906	4140	4101
16			26	59	49	37	49	31	13	-
Дүн	7650	7749	8643	8843	9583	11110	12043	12274	12616	11231

Хүснэгт 4. Хонь, толгой

Хороо	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
6	604	278	297	325	171	185	221	24	36	-
7	2	1	-	4	-	-	-	-	-	-
8	211	-	-	-	-	-	128	164	34	-
9	158	71	7	-	-	-	-	-	299	-
10	365	372	124	335	239	269	297	196	78	-
11	51	90	90	48	43	20	-	-	-	-
12	2731	810	1144	1119	1173	1043	986	714	1086	576
13	8838	3330	3432	3406	3628	5435	4731	3986	3268	2910
14	4222	3411	3552	6121	6320	7380	3581	4874	5093	5090
16	-	-	35	10	10	-	-	-	-	-
Дүн	17182	8363	8681	11368	11586	14332	9944	9958	9894	8576

Хүснэгт 5. Ямаа, толгой

Хороо	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
4	4	-	-	-	-	-	-	-	-	-
6	503	214	269	248	142	124	148	34	46	-
7	18	5	7	7	-	-	-	-	-	-
8	215	11	-	0	-	-	194	174	100	-
9	410	275	57	14	-	-	-	-	460	-
10	898	368	229	306	527	478	341	161	108	-
11	149	246	5	86	28	6	-	-	-	-
12	5029	1819	2121	1942	2084	1849	2154	1685	1848	1270
13	9410	3533	3885	3090	3275	4004	3960	3380	3583	2889
14	4403	3189	3646	4870	4175	4873	2817	3736	3582	3494
16	-	-	284	150	200	-	-	-	-	-
Дүн	21039	9660	10503	10713	10431	11334	9614	9170	9727	7653

Хүснэгт 6. Хээлтэгч малын тоо төрлөөр, тоо

Он	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2010	15110	1	952	3856	4473	5828
2011	14600	14	976	4280	4220	5110
2012	16910	15	1263	4251	5845	5536
2013	16569	2	1365	4507	5491	5204
2014	19471	8	1685	5146	7137	5495
2015	16572	-	1591	5585	4833	4563
2016	17812	4	2207	6072	4957	4572
2017	17637	1	1966	6259	4782	4629
2018	16737	1	2158	6105	4434	4039

Хүснэгт 7. Хээлтүүлэгч малын тоо, төрлөөр, толгой

Хороо	Бүгд	Үүнээс:				
		Буур	Азрага	Бүх	Хуц	Ухна
2008	400	-	117	69	116	120
2009	528	-	201	64	126	137
2010	518	-	319	73	66	60
2011	499	1	290	67	92	49
2012	584	1	318	85	88	92
2013	614	-	346	92	86	90
2014	636	2	331	98	114	91
2015	590	-	345	97	71	77
2016	643	-	418	114	56	55
2017	535	-	325	106	56	48
2018	537	-	350	110	41	36

Хүснэгт 8. Бойжсон төл, төрлөөр, толгой

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
2008	12492	-	271	2108	4861	5252
2009	14069		351	2242	5225	6251
2010	5630		286	2454	1632	1258
2011	11443	5	620	2850	3569	4399
2012	12073	5	825	3185	3984	4074
2013	15805	6	937	3578	5564	5720
2014	13945		929	3641	4509	4866
2015	15988	4	1002	4103	5835	5044
2016	13181	1	1211	4341	4081	3547
2017	14180	2	1469	5038	4073	3598
2018	11044	-	931	4055	3327	2731

Хүснэгт 9. Том малын зүй бүс хорогдол, төрлөөр, толгой

Он	Бүгд	адуу	үхэр	хонь	ямаа
2008	247	6	121	51	69
2009	166	17	37	44	68
2010	20754	862	1373	8380	10139
2011	249	17	116	48	68
2012	165	3	74	44	44
2013	231	20	89	72	50
2014	293	9	89	63	132
2015	552	36	152	120	244
2016	751	83	281	187	200
2017	1070	142	395	280	253
2018	1775	287	432	477	579

Хүснэгт 10. Хээл хаясан хээлтэгч малын тоо, толгой

Он	Бүгд	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
2008	451	29	55	112	255
2009	518	14	66	128	310
2010	1034	39	79	373	543
2011	245	28	60	75	82
2012	373	16	42	130	185
2013	349	23	34	185	107
2014	367	17	31	179	140
2015	233	22	30	69	112
2016	762	70	57	254	381
2017	1936	277	554	649	456
2018	1084	260	186	213	425

Хүснэгт 11. Сувайрсан хээлтэгч малын тоо, толгой

Он	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
2008	1788	1	55	685	247	800
2009	2329	1	82	671	620	955
2010	1478		137	475	321	545
2011	1089		136	331	253	369
2012	1544	4	204	525	249	562
2013	1234	1	202	501	334	196
2014	2289	1	370	619	748	551
2015	2155		309	763	609	474
2016	2710	1	436	1178	436	659
2017	2313		405	946	460	502
2018	4531		776	1549	1101	1105

Хүснэгт 12. Малтай өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр

Малын тооны бүлэг	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
10 хүртэл	425	532	442	395	345	357	325	330	328	267
11-30	216	277	220	235	238	246	261	249	249	201
31-50	77	66	77	62	84	76	81	90	70	87
51-100	82	92	59	58	63	60	70	90	85	80
101-200	71	46	45	53	34	40	41	37	35	34
201-500	52	17	30	27	37	43	31	30	32	20
501-999	9	4	4	9	7	7	5	8	8	9
1000-1499	1	-	-	1	1	3	2	1	1	1
1500-2000	-	-	-	-	-	-	-	1	1	1
Дүн	933	1034	877	840	809	832	816	836	809	700

Хүснэгт 13. Малтай болон малчин өрхийн тоо

он	Малтай өрх	Үүнээс:Малчин өрх	Малчдын тоо	Үүнээс:Эмэгтэй
2006	926	124	210	41
2007	984	293	644	208
2008	851	300	605	192
2009	933	178	3187	547
2010	1034	179	324	98
2011	877	283	648	274
2012	956	56	110	50
2013	809	100	185	85
2014	832	104	209	100
2015	816	106	216	95
2016	836	206	389	164
2017	809	153	281	108
2018	700	182	288	117

Хүснэгт 14. Малчдын насны бүрэлдэхүүн

Насны бүлэг	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
6-14									6	
15-34	191	58	113	31	42	59	57	85	79	75
35-54 насны эм, 35-59 насны эр	213	169	372	63	125	122	140	252	163	185
55 ба түүнээс дээш насны эм, 60 ба түүнээс дээш насны эр	143	97	165	16	18	28	19	52	33	28
Дүн	547	324	648	110	185	209	216	389	281	288

Хүснэгт 15. Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлт

Өрхийн үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Цахилгаан гэрэлтэй	178	176	287	55	87	103	101	136	154	123
Телевизортой	169	177	286	54	74	96	97	135	121	108
Автомашинтай	86	88	103	46	117	125	223	357	259	267
Мотоциклтэй	18	19	285	11	40	7	32	39	36	64

Хүснэгт 16. Малын хашаа, худгийн тоо

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Хашаа	178	183	285	886	961	887	977	1005	961	1058
Худаг	32	13	32	45	141	187	267	206	203	234

Хүснэгт 17. Тэжээвэр амьтдын тоо

Он	Гахай	Үүнээс:Мэгж	Шувуу	Үүнээс: өндөглөгч
2008	5137	688	215354	177893
2009	6818	642	240915	157141
2010	8121	772	252069	181102
2011	5976	737	379971	310338
2012	5952	794	284729	269158
2013	6555	1042	240672	240570
2014	7901	1138	274887	274676
2015	5926	752	269307	218506
2016	5007	101	322527	318479
2017	4174	30	360722	250009
2018	3753	467	391542	360344

Хүснэгт 18. Гахай, шувууны аж ахуйн бүтээгдэхүүн

Он	Гахайн мах (тн)	Шувууны мах(кг)	Өндөг (мян.ш)
2008	21.6	68600.0	45200.0
2009	60.0	56466.0	28593.3
2010	80.0	64855.0	37886.4
2011	216.3	226432.8	55438.0
2012	133.2	59900.0	42642.9
2013	199.2	69686.0	22239.3
2014	360.9	132642.0	48190.9
2015	37.0	89120.0	43238.3
2016	296.0	119630.0	55801.3
2017	88.2	91800.0	71957.3
2018	329.0	115800.0	111935.0

Хүснэгт 19. Гэрийн тэжээвэр нохой, муурны тоо, оноор

Он	Нохой		Муур	
	Бүгд	үүнээс: орон сууцанд	Бүгд	үүнээс: орон сууцанд
2008	4927	128	91	3
2009	4902	129	139	11
2010	4554	124	143	13
2011	4977	119	153	14
2012	5019	177	164	18
2013	5695	91	184	20
2014	5897	119	215	21
2015	5804	94	233	17
2016	5912	89	118	10
2017	5540	86	128	10
2018	5630	183	222	16

Хүснэгт 20. Гэрийн тэжээвэр нохойны тоо, хороогоор

Хороо	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	65	76	71	22	22	18	20	21	13	22	24
2	39	30	30	38	40	42	63	37	37	28	33
3	22	23	23	23	16	14	16	13	13	13	55
4	543	466	350	328	375	332	359	350	316	320	257
5	418	454	326	326	331	408	438	439	455	456	420
6	660	606	542	563	562	558	484	500	475	473	353
7	433	370	368	400	431	354	364	321	371	351	354
8	653	840	840	869	876	836	852	822	761	753	786
9	693	780	780	654	644	642	724	802	752	752	798
10	333	394	394	330	356	356	347	458	628	634	505
11	71	118	118	78	99	100	106	105	75	72	41
12	551	164	129	138	138	527	507	402	434	121	396
13	258	258	258	258	184	371	515	494	585	590	513
14	188	323	325	325	327	518	477	483	544	527	561
15	-	-	-	24	23	17	20	23	26	23	30
16	-	-	-	601	595	602	605	534	427	405	504
Бүгд	4927	4902	4554	4977	5019	5695	5897	5804	5912	5540	5630

Хүснэгт 21. Гэрийн тэжээвэр муурын тоо, хороогоор

Хороо	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	1	8	10	9	7	10	10	8	3	6	3
2	1	2	2	2	2	4	6	3	3	-	2
3	-	1	1	1	0	3	3	3	3	3	3
4	-	6	9	4	2	4	4	4	-	2	54
5	5	4	4	4	5	12	17	17	-	17	7
6	23	22	10	19	27	3	13	9	10	9	6
7	6	5	6	9	9	5	9	5	7	7	4
8	7	16	16	22	15	15	13	15	13	5	5
9	3		0	1	2	6	4	5	-	-	3
10	8	9	9	2	1	20	18	39	-	6	11
11	3	11	11	9	9	5	6	6	2	3	6
12	-	10	10	14	18	37	28	27	9	2	42
13	31	36	36	36	27	49	70	59	39	37	54
14	3	9	19	19	26	4	6	24	27	22	20
15	-	-	-	1	1	1	2	3	1	3	2
16	-	-	-	1	13	6	6	6	1	6	-
Бүгд	91	139	143	153	164	184	215	233	118	128	222



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Статистик

Мэдээ, мэдээлэл

Номын сан

Мэдлэгээ шалгах тоглоом

Валютын ханш



1212.mn аппликейшнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН



WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик

Мэдээ, мэдээлэл

Номын сан

Мэдлэгээ шалгах тоглоом

Валютын ханш



аппликейшнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай



Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



SOCIAL NETWORK



[www.facebook.com/
StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)

ЛАВЛАХ УТАС



1900-1212

ЦАХИМ ШУУДАН



information@nso.mn